

**“Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлыг  
санхүүжүүлэх, гүйцэтгэх, үр дүнг тооцох журам”-ын  
шинэчилсэн найруулгын төсөл**

**Нэг. Нийтлэг үндэслэл**

- 1.1. Ашигт малтмалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.6 дахь заалт, 16 дугаар зүйлд заасан улсын төсвийн хөрөнгө (цаашид “УТХ” гэх)-өөр гүйцэтгэх геологийн судалгааны ажил (цаашид “ГСА” гэх)-ыг санхүүжүүлэх, гүйцэтгэх, үр дүнг тооцох харилцааг энэ журмаар зохицуулна.
- 1.2. УТХ-өөр гүйцэтгэх ГСА-ыг санхүүжүүлэх, гүйцэтгэх, үр дүнг тооцох журам нь Захиргааны ерөнхий хууль, Газрын хэвлийн тухай хууль, Ашигт малтмалын тухай хууль болон холбогдох бусад хууль, журмын хүрээнд зохицуулагдана.
- 1.3. ГСА-д Ашигт малтмалын тухай хуулийн 11<sup>1</sup> дүгээр зүйлд зааснаар УТХ-өөр гүйцэтгэх геологи, геофизик, геохими, гидрогеологи, геоэкологийн зураглал, сэдэвчилсэн судалгаа, эрэл, хайгуул хийх, ашигт малтмалын тархалтын зүй тогтол, минерагений судалгаа хийж, хэтийн төлөвийн үнэлгээ өгөх, геологи, эрдэс баялгийн мэдээллийн сан бүрдүүлэх, түүнийг баяжуулах зэргийг хамруулж ойлгоно.
- 1.4. ГСА-д улсын төсвөөс зарцуулах төсвийн ерөнхийлөн захирагч нь геологийн асуудал эрхэлсэн сайд (цаашид “сайд” гэх), сайдаас эрх олгосоны дагуу төсвийг хуваарилах, зарцуулах, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах төсвийн шууд захирагч нь геологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болох Үндэсний геологийн алба (цаашид “ҮГА” гэх)-ны дарга (цаашид “ҮГА-ны дарга” гэх) байна.

**Хоёр. Геологийн судалгааны ажлыг санхүүжүүлэх**

**2.1. Геологийн судалгааны ажлын төсөл, төсөвт тодотгол хийх**

- 2.1.1. ГСА-ын төсөл гүйцэтгэгч (цаашид “гүйцэтгэгч” гэх) нь гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл, сонгон шалгаруулалтын үйл ажиллагаа, санхүүжилтийн хоцрогдол зэрэг шалтгааны улмаас (а) төсөл гүйцэтгэх хугацааг сунгуулах, (б) ГСА-ын арга аргачлал, хэмжээнд нэмэлт, өөрчлөлт оруулах болон (в) магадлашгүй ажлын зардлыг ашиглах саналаа жил бүрийн 1 дүгээр сарын 31-ний дотор ҮГА-нд албажуулан ирүүлнэ.
- 2.1.2. Гүйцэтгэгч нь тухайн жилийн ажлын арга, аргачлал, хэмжээ, төсвийн тодотгол болон зарчмын зөрүүтэй шийдвэрлүүлэх асуудлын саналыг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл (цаашид “ЭБМЗ” гэх)-ийн хуралдаанаар хэлэлцүүлэхдээ (а) төсөл гүйцэтгэх хугацаанд хийсэн ажлын хэмжээ, гүйцэтгэл, төсвийн дүн, (б) гадны байгууллагаар гүйцэтгүүлсэн ажлын хэмжээ, гүйцэтгэл, төсвийн дүн, (в) илүү, дутуу гүйцэтгэсэн ажлын хэмжээ, төсвийн дүнг жил бүрээр гаргаж, (г) өөрийн хүчээр гүйцэтгэсэн ажлын санхүүжилт аваагүй гүйцэтгэлийг дараа оны ГСА-ын төсөв, төлөвлөгөөнд тусгуулах саналаа 1, 2 дугаар хавсралтын дагуу бэлтгэн энэ журмын 2.1.1-д заасан хугацаанд ҮГА-нд ирүүлнэ.
- 2.1.3. ҮГА нь ГСА-ын арга, аргачлал, хэмжээ, төсөвт оруулах өөрчлөлтийн саналыг жил бүрийн 2 дугаар сарын 20-ны дотор хянаж 4 дүгээр сарын 25-ны дотор ЭБМЗ-өөр хэлэлцүүлэн, дүгнэлт гаргуулсан байна.
- 2.1.4. ҮГА-ны дарга нь ЭБМЗ-өөс гаргасан дүгнэлтийг үндэслэн төсөл тус бүрийн ажлын арга, аргачлал, хэмжээ, төсвийн тодотголыг жил бүрийн 5 дугаар сарын 10-ны дотор шийдвэрлэсэн байна.
- 2.1.5. ҮГА нь үргэлжлэн хэрэгжиж байгаа ГСА-ын гүйцэтгэгчээс ирүүлсэн тухайн жилийн төсвийн тодотголд үнийн тохируулга оруулах саналыг үндэслэлтэй

гэж үзвэл геологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага (цаашид “яам” гэх)-ын холбогдох нэгжид танилцуулж, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага (цаашид “Сангийн яам” гэх)-д уламжлан шийдвэрлүүлнэ.

- 2.1.6. УГА нь ГСА-уудын тухайн жилийн төсөвт батлагдсан магадлашгүй ажлын зардлыг тухайн төслийг гүйцэтгэх явцад гарсан урьдчилан тооцоолох боломжгүй нөхцөл үүссэн тохиолдолд ГСА-ыг санхүүжүүлэх зорилгоор зарцуулах эсэх асуудлыг шуурхай хяналтын тэмдэглэл, гүйцэтгэгчээс гаргасан саналыг хэлэлцсэн ЭБМЗ-ийн дүгнэлтийг үндэслэн шийдвэрлэнэ.
- 2.1.7. УГА нь үргэлжлэн хэрэгжиж байгаа төслүүдийн тухайн онд батлагдсан төсвийн тодотгол, шинээр гүйцэтгэх төслүүдийн тухайн оны гэрээнд тусгагдсан төсвийн дүнг энэ журмын 3, 4 дүгээр хавсралтын дагуу нэгтгэсэн төсөв, төлөвлөгөөний тодотголын санал, өөрчлөлт оруулах үндэслэл бүхий танилцуулга, ЭБМЗ-ийн дүгнэлт, УГА-ны даргын шийдвэр, шинээр эхэлсэн төслүүдийн гэрээ (эх хувь)-ний хамт 6 дугаар сарын 10-ны дотор яамны геологийн асуудал хариуцсан нэгжээр хянуулж, сайдаар батлуулан Сангийн яаманд хүргүүлнэ.
- 2.1.8. УГА нь тухайн жилийн ГСА-уудын суурин боловсруулалт болон хээрийн ажил дуусгавар болсны дараа гүйцэтгэгчээс ирүүлсэн хүсэлт, шуурхай хяналтын тэмдэглэл, хээрийн ажил хүлээн авсан тэмдэглэл, холбогдох нотлох баримтыг үндэслэн ГСА-ын төсөлд тусгасан биет хэмжээнээс илүү, дутуу гүйцэтгэсэн ажлын гүйцэтгэл, төсвийг жил бүрийн 11 дүгээр сарын 20-ны дотор нэгтгэнэ.
- 2.1.9. УГА нь сайдын төсвийн багцад батлагдсан санхүүжилтийн эх үүсвэрийг ГСА-д бүрэн зарцуулахын тулд төслүүдийн төсөвт тусгасан биет хэмжээнээс илүү, дутуу гүйцэтгэсэн ажлын санхүүжилтийг тухайн онд багтаан гүйцэтгэгч нарт олгох саналаа энэ журмын 3, 4 дүгээр хавсралтын дагуу боловсруулан, өөрчлөлт оруулах үндэслэл бүхий танилцуулга болон холбогдох нотлох баримтын хамт яамны геологийн асуудал хариуцсан нэгжээр 11 дүгээр сарын 30-ны дотор хянуулж, сайдаар батлуулан Сангийн яаманд хүргүүлнэ.
- 2.1.10. УГА нь түймэр, үер, халдварт өвчин, газар хөдлөлт, хорио цээр, тээврийн хориг зэрэг гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдал үүссэн, мөн урьдчилан тооцоолох боломжгүй нөхцөлийн улмаас санхүүжилт 90 хоногоос илүү хугацаагаар хоцорсон тохиолдолд ГСА-ын хугацааг гүйцэтгэгч талын санал, нотлох баримтыг үндэслэн сунгах бөгөөд сунгасан шийдвэрийг яамны геологийн асуудал хариуцсан нэгжид тухай бүр мэдэгдэнэ.
- 2.1.11. Гүйцэтгэгч нь гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдал үүссэн тохиолдолд нэн даруй УГА-нд албан бичгээр мэдэгдэнэ.

## **2.2. Геологийн судалгааны ажлын гүйцэтгэл гаргах, тайлагнах**

- 2.2.1. Гүйцэтгэгч нь тухайн жилийн төсөв батлагдсаны дараа төсөл тус бүрийн ажлын гүйцэтгэлийг энэхүү журмын 5 дугаар хавсралтын дагуу үнэн зөв, алдаа, засваргүй 3 хувь үйлдэж сар бүрийн 20-ны дотор УГА-нд албажуулан хүргүүлнэ.
- 2.2.2. Гүйцэтгэгч нь жил бүрийн ГСА-ын гүйцэтгэл, түүний зардлын задаргааг ажлын нэр төрөл бүрээр 6 дугаар хавсралтын дагуу гаргаж ГСА-ын эхний хагас жил (6 дугаар сарын 20-ны дотор) болон жилийн эцсийн тайлан (11 дүгээр сарын 20-ны дотор)-д хавсарган УГА-нд тайлагнана.
- 2.2.3. Энэ журмын 2.2.1-д заасан гүйцэтгэлийн үнэн зөв, алдаагүй болохыг тухайн ГСА гүйцэтгэгч хуулийн этгээд хариуцах бөгөөд ажлын гүйцэтгэлийг худал

мэдүүлж санхүүжилт авсан нь тодорхой баримт, нотолгоогоор тогтоогдвол холбогдох хууль, журамд заасны дагуу хариуцлага тооцно.

### **2.3. Геологийн судалгааны ажлын гүйцэтгэлийг санхүүжүүлэх**

- 2.3.1. Гүйцэтгэгч нь ГСА гүйцэтгэх гэрээ, өмнөх онд хийгдсэн ажлын хэмжээ, санхүүжилт авсан төсвийн өөрчлөлт, ирэх онд хийгдэх ажлын хэмжээ, шаардагдах төсвийн төсөөлөл зэргийг уялдуулан сар бүрийн төсвийн хуваарийн саналыг боловсруулж, ҮГА-нд жил бүрийн 12 дугаар сарын 15-ны дотор хүргүүлнэ.
- 2.3.2. ҮГА нь журмын 2.3.1-д ирсэн саналыг үндэслэн төсөл тус бүрээр сар болгоны төсвийн хуваарийг энэ журмын 7 дугаар хавсралтын дагуу нэгтгэн боловсруулж жилийн бүрийн 12 дугаар сарын 20-ны дотор яамны санхүүгийн асуудал хариуцсан нэгжид хүргүүлнэ. Тус нэгж нь төлөвлөгөөт онд сайдын багцад батлагдсан салбарын хэмжээний төсвийн хуваарьт нэгтгэн Сангийн яаманд 12 дугаар сарын 25-ны дотор хүргүүлнэ.
- 2.3.3. ҮГА нь журмын 2.2.1-д заасны дагуу гүйцэтгэгчээс ирүүлсэн гүйцэтгэлийг хянаж энэ журмын 8 дугаар хавсралтын дагуу нэгтгэнэ. Гүйцэтгэлийн нэгтгэлийг ҮГА-ны дарга батласны дараа 3 хувь үйлдэн сар бүрийн 25-ны дотор санхүүжилтийн эрх нээлгэхээр Сангийн яаманд албажуулан хүргүүлнэ.
- 2.3.4. ҮГА нь эрх нээгдмэгц ГСА-ын дансаар дамжуулан гэрээнд заасан төсөл гүйцэтгэгчийн харилцах дансанд санхүүжилтийг шуурхай шилжүүлнэ.
- 2.3.5. ҮГА нь санхүүжилтийн эрх хязгаартай нээгдсэн тохиолдолд ямар нэгэн ашиг сонирхолын үүднээс тэгш бус хандлага гаргахгүйгээр баталгаажсан сар бүрийн гүйцэтгэлд нь хувь тэнцүүлэн тооцож ажлын 3 өдөрт багтаан олгоно.
- 2.3.6. Гүйцэтгэгч санхүүжилтийн дансаа солисон тохиолдолд ажлын 3 өдрийн дотор ҮГА-нд албан бичгээр мэдэгдэнэ.
- 2.3.7. Гүйцэтгэгч нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон ГСА гүйцэтгэх гэрээнд заасны дагуу гүйцэтгэлийн баталгааг хугацаагүй гаргаж гэрээнд хавсаргана.
- 2.3.8. Гүйцэтгэгч нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасны дагуу тухайн жилд гүйцэтгэсэн ажлын гүйцэтгэлийг нийт гүйцэтгэх ажилтай харьцуулсан хувьтай тэнцүү хувиар гүйцэтгэлийн баталгааг чөлөөлүүлэх хүсэлтээ жил бүрийн 4-р сарын 15-ны дотор ҮГА-нд хүргүүлнэ.
- 2.3.9. ҮГА нь гүйцэтгэгчээс ирүүлсэн хүсэлтийг судлан тухайн жилд гүйцэтгэсэн ажлын хувьтай тэнцүү хувиар гүйцэтгэлийн баталгааг чөлөөлөх шийдвэрийг хүсэлт ирснээс хойш ажлын 5 өдөрт багтаан гаргаж холбогдох банкинд албажуулан хүргүүлнэ.
- 2.3.10. ГСА-ын сүүлийн 2 жилд ногдох гүйцэтгэлийн баталгааг чөлөөлөхгүй бөгөөд ҮГА, гүйцэтгэгч тал ГСА гүйцэтгэх гэрээг дүгнэсний дараа гүйцэтгэлийн баталгааг чөлөөлнө.
- 2.3.11. ҮГА нь Сангийн яамнаас баталсан дүрэм, журам, стандартад нийцүүлэн боловсруулсан ГСА-ын улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 15-ны дотор, жилийн төсвийн гүйцэтгэл, аудит хийсэн санхүүгийн тайланг жил бүрийн 2 дугаар сарын 25-ны дотор сайдын санхүүгийн тайланд нэгтгүүлэхээр яаманд хүргүүлнэ.

### **Гурав. Геологийн судалгааны ажлыг гүйцэтгэх**

#### **3.1. Геологийн судалгааны ажлын төлөвлөлт, төсөв, төлөвлөгөө, даалгаврыг батлуулах**

- 3.1.1. ГСА-ыг гүйцэтгэхэд Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын дагуу бүс нутгийн хөгжлийг жигд хангах зорилгоор геологийн тогтоцыг нарийвчлан судлах, давхраажсан хурдас, гүний чулуулгийг ангилах, нас тогтоох, металлогений муж, бүс, голлох хүдрийн дүүрэг, зангилаануудыг бүрхэх, дэлхийн болон бүс нутаг, улс орны зах зээл дээр стратегийн ач холбогдолтой эрдэс түүхий эдийг богино хугацаанд бага зардлаар судлан, үр дүнд хүрэх зарчмыг баримтлана.
- 3.1.2. ҮГА нь дараа онуудад УТХ-өөр шинээр гүйцэтгэх ГСА-ыг төлөвлөхөдөө холбогдох агентлаг, аймаг, нийслэлийн Засаг дарга, салбарын мэргэжлийн холбоод, эрдэм шинжилгээний байгууллага, эрдэмтэд, их, дээд сургуулийн саналыг жил бүрийн 10 дугаар сарын 15-ны дотор авч нэгтгэнэ.
- 3.1.3. ҮГА нь энэ журмын 3.1.1-д заасан зарчмыг баримтлан дараа онуудад гүйцэтгэхээр энэ журмын 3.1.2-ын дагуу ирүүлсэн ГСА-ын саналыг ач холбогдолоор нь эрэмбэлсэн төсөв, төлөвлөгөөний төсөл болон дунд хугацааны төлөвлөлт, төсвийн төсөөллийг нэгтгэн боловсруулж 12 дугаар сарын 15-ны дотор яамны геологийн асуудал хариуцсан нэгжид хүргүүлнэ.
- 3.1.4. Яамны геологийн асуудал хариуцсан нэгж нь жил бүрийн 1 дүгээр сарын 05-ны дотор дараа онуудад гүйцэтгэх ГСА-ын төсөв, төлөвлөгөөний төсөл, төсөөллийг хянаж Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө болон дараа оны төсвийн хүрээний мэдэгдэл, дунд хугацааны төлөвлөлт, төсвийн төсөөллийн саналыг боловсруулан эдийн засгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Сангийн яаманд хүргүүлнэ.
- 3.1.5. ҮГА нь сайдын төсвийн багц батлагдмагц төлөвлөгөөт онд үргэлжлэн хэрэгжих болон шинээр эхлэх ГСА-ын төсөл тус бүрт хуваарилах төсвийн болон гүйцэтгэх ажлын төлөвлөгөөний санал, төсөв хуваарилсан үндэслэл бүхий танилцуулгыг жилийн бүрийн 12 дугаар сарын 05-ны дотор яаманд хүргүүлнэ.
- 3.1.6. ҮГА нь шинээр хэрэгжүүлэх төслийн нэр, код, талбайн хэмжээ, байршил, хавтгайн дугаар, хэрэгжих хугацаа, төсөвт өртөг, тухайн жилд санхүүжүүлэх төсөв, нэгж өртөг тооцсон үндэслэлийг энэ журмын 9 дүгээр хавсралтын дагуу боловсруулан журмын 3.1.5-д заасан саналд хавсаргана.
- 3.1.7. Яамны геологийн асуудал хариусан нэгж нь ҮГА-ны саналыг үндэслэн төлөвлөгөөт онд хэрэгжүүлэх ГСА-ын төсөв, төлөвлөгөөг энэ журмын 3, 4 дүгээр хавсралтын дагуу боловсруулан холбогдох хуульд заасан хугацаанд багтаан батлуулж СЯ, ҮГА, гүйцэтгэгч нарт хүргүүлнэ.
- 3.1.8. Яамны худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан нэгж нь энэ журмын 3.1.6-д заасны дагуу ҮГА-аас ирүүлсэн саналыг яамны геологийн асуудал хариуцсан нэгжээр хянуулж сайдын худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, жагсаалтад нэгтгэн батлуулж холбогдох газруудад албажуулан хүргүүлнэ.
- 3.1.9. ҮГА нь төлөвлөгөөт онд шинээр хэрэгжүүлэх ГСА-ын геологийн даалгаврын төсөлд салбарын мэргэжлийн холбоод, эрдэм шинжилгээний байгууллага, эрдэмтэд, их, дээд сургуулиас санал авч нэгтгэн, яамны геологийн асуудал хариуцсан нэгжээр 11 дүгээр сарын 30-ны дотор хянуулж 12 дугаар сарын 31-ний дотор ҮГА-ны даргаар батлуулна.

## **3.2. Геологийн судалгааны ажлыг гүйцэтгэх, гүйцэтгүүлэх**

- 3.2.1. Гүйцэтгэгч нь ГСА-ыг батлагдсан гэрээ, геологийн даалгавар, төсөлд тусгасны дагуу холбогдох заавар, түүнд тавигдах шаардлагад нийцүүлэн хэрэгжүүлэх бөгөөд орчин үеийн шинэ техник, технологи, шинжлэх ухааны дэвшилтэт арга, аргачлалыг нэвтрүүлж ажлыг чанартай гүйцэтгэнэ.
- 3.2.2. Гүйцэтгэгч нь төслийн хүрээнд бусдаар гүйцэтгүүлэх ажил буюу геофизикийн ажил, ажлын хэрэгцээний байр зүйн зураг, агаар болон

- сансрын зураг, түүний тоон мэдээлэл, тайлангийн зургуудыг захиалж хэвлүүлэх болон бусад шаардлагатай ажил, үйлчилгээ, бараа материал гэх мэтийг гэрээ байгуулан гүйцэтгүүлнэ.
- 3.2.3. Гүйцэтгэгч нь ГСА-ын дээж, сорьцын шинжилгээг Геологийн төв лаборатори болон итгэмжлэгдсэн бусад лабораторитой гэрээ байгуулан гүйцэтгүүлнэ.
  - 3.2.4. Гүйцэтгэгч нь төслийн хүрээнд бусдаар гүйцэтгүүлсэн ажлын гэрээг дүгнэж, төлбөр тооцоог бүрэн барагдуулсан баримтыг ГСА-ын үр дүнгийн тайланд хавсаргасан байна.
  - 3.2.5. Геологийн даалгавраар өгөгдсөн асуудлуудыг судалгааны оновчтой шинэлэг арга аргачлал, шинжлэх ухааны үндэслэлтэйгээр гүйцэтгэж, онолын хувьд маргаантай байгаа асуудлыг шийдвэрлэх ач холбогдол бүхий баримтыг олж тогтоосон болон ашигт малтмалын хувьд хэтийн төлөвтэй эсэхийг бүрэн эцэслэж, ирээдүйд орд болгох боломж их болохыг тогтоож, тайланг хугацаанд нь онцсайн хамгаалсан гүйцэтгэгчийг төсөлд зарцуулсан нийт зардлын дүнгийн 1 хүртэл хувь хэмжээгээр урамшуулан шагнаж болно. Шагналын хувь, хэмжээг ЭБМЗ-ийн хурлын дүгнэлтийг үндэслэн сайдын шийдвэрээр олгоно.
  - 3.2.6. Гүйцэтгэгч нь УГА-аас баталсан маягтын дагуу төсөл тус бүрээр геологийн даалгаврын биелэлтийн үр дүнг дэлгэрэнгүй тусгасан тайланг улирал бүрийн сүүлийн сарын 25-ны дотор УГА-нд цахим болон цаасан хувиар албажуулан хүргүүлнэ.
  - 3.2.7. УГА нь ГСА-ын улирлын тайланг нэгтгэн улирал бүрийн дараа сарын 5-ны дотор яаманд цахим болон цаасан хувиар албажуулан хүргүүлнэ.
  - 3.2.8. УГА-ны дарга нь ГСА-ын төсөл тус бүрийн (а) суурин боловсруулалт, хээрийн ажлын гүйцэтгэл, явцад шуурхай хяналт хийх, (б) хээрийн анхдагч материал хүлээн авах, хяналт тавих үүрэг бүхий яам болон УГА-ны асуудал хариуцсан нэгжийн албан хаагчдаас бүрдсэн комисс (цаашид “комисс” гэх)-ыг томилон ажиллуулна. Мөн ГСА-ын гүйцэтгэгч нарыг судалгааны арга зүйгээр хангах, зөвлөгөө өгөх үүрэг бүхий Монголын стратиграфийн комисс (цаашид “МСК” гэх), Редакцийн зөвлөл (цаашид “РЗ” гэх)-ийн гишүүдээс бүрдсэн багийг томилон ажиллуулна.
  - 3.2.9. Комиссын бүрэлдэхүүнд салбарын тэргүүлэх эрдэмтэд, мэргэжилтнүүдийг ашиг сонирхолын зөрчил үүсгэхгүй байхаар сонгон оролцуулж болно. Шаардлагатай тохиолдолд ашигт малтмалын чиглэлээр аргазүйн зөвлөгөө өгөх үүрэг бүхий салбарын тэргүүлэх судлаач, эрдэмтэн, мэргэжилтнүүдээс бүрдсэн багийг томилон ажиллуулж болно.
  - 3.2.10. Комисс нь гүйцэтгэгчийн ажлын үр дүн болон ажлын гүйцэтгэлийг баталгаажуулах зорилгоор хээрийн судалгааны болон суурин боловсруулалтын ажлын гүйцэтгэлд шуурхай хяналтыг гүйцэтгэн ГСА зохих арга, аргачлал, хэмжээний дагуу хэрэгжиж байгаа эсэх, төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж байгаа эсэхийг шалгах болон маргаантай, хүндрэлтэй асуудлыг тухай бүр судлан арга, аргачлалын зөвлөмж өгч ажиллана.
  - 3.2.11. Шуурхай хяналтын үед ажлын гүйцэтгэлийг газар дээр нь холбогдох баримт материал, мэдээ, мэдээлэлтэй танилцах, хэмжилт хийх замаар баталгаажуулж, энэ тухай тэмдэглэл үйлдэнэ. Гүйцэтгэгч нь ГСА-тай холбоотой бүх баримт материал, мэдээ, мэдээллийг комисст саадгүй үзүүлэх, танилцуулах, мөн хүргүүлнэ.
  - 3.2.12. Хээрийн судалгааны үед геологийн даалгаварт тусгасан асуудлыг шийдвэрлэхийн тулд тухайн үед шинээр тогтоосон үр дүн, баримтыг үндэслэн ажлын арга аргачлал, хэмжээнд шаардлагатай нэмэлт, өөрчлөлт оруулах гүйцэтгэгчийн саналыг комисс газар дээр нь хянан баталгаажуулна. Тус комисс нь тухайн төслийн ажилд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

саналын үндэслэл, хийх арга замыг тодорхой дурдсан илтгэх хуудас боловсруулан ҮГА-нд хүргүүлэх бөгөөд ҮГА нь асуудлыг судалж шийдвэрлэнэ.

- 3.2.13. Шуурхай хяналт хийх, хээрийн материал хүлээн авахад ГСА-ын гэрээ, геологийн даалгавар болон арга, аргачлал зөрчсөн, хийгээгүй ажлыг гүйцэтгэлд оруулж илүү санхүүжилт авсан нь тогтоогдвол уг ажлыг нөхөн хийлгэх, ажлын гүйцэтгэлээс хасах, ажлын биет хэмжээг холбогдох зардлын хамт санхүүжүүлэхээс татгалзах, ажлыг зогсоох саналыг комиссын гишүүдийн олонхийн саналаар ҮГА-нд хүргүүлж шийдвэрлүүлнэ.
- 3.2.14. МСК, РЗ нь батлагдсан удирдамжийн дагуу төсөл тус бүрийн судалгааны ажилд үүссэн маргаантай болон хүндрэлтэй асуудлыг судлаж мэргэжил аргагүйн зөвлөмж өгч ажиллах бөгөөд шийдвэрлэсэн асуудлын талаарх илтгэх хуудсыг ҮГА-нд танилцуулна.
- 3.2.15. Комисс, МСК, РЗ-ийн үйл ажиллагааны зардал, хяналт тавих, ажлын гүйцэтгэлийг хэмжин шалгахад шаардагдах багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж авах, судалгааны явцад гарсан маргаантай асуудлыг шийдвэрлэхээр дээж, сорьц авч лабораторийн шинжилгээ хийлгэх, ГСА-тай холбоотой арга аргачлал, заавар, зөвлөмж, норм боловсруулах, үр дүнгийн тайланд шүүмж бичүүлэх, ЭБМЗ-ийн улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэсэн ГСА-ын үр дүнг хэлэлцэх салбар зөвлөлийн үйл ажиллагааны зардал, ГСА-ыг үр дүнтэй гүйцэтгэж, тайланг ЭБМЗ-өөр онцсайн хамгаалсан гүйцэтгэгчийг урамшуулан шагнах зардлыг ГСА-ын аргачлал, хяналтын зардлаас санхүүжүүлнэ.
- 3.2.16. Мэргэжлийн холбоод, их, дээд сургууль, эрдэмтэдтэй хамтран салбарын боловсон хүчнийг давтан сургах, дадлагажуулах зорилгоор хээрийн болон танхимын сургалтыг зохион байгуулахад аргачлал, хяналтын зардлаас жил бүр тодорхой хэмжээний төсвийг зарцуулна.
- 3.2.17. ҮГА нь тухайн жилийн аргачлал, хяналтын зардлын төсвийг төсөл тус бүрийн тухайн жилд өөрийн хүчээр гүйцэтгэх ажлын нийт дүнгийн 2 хүртэл хувьтай тэнцэх төсвийг төсөл гүйцэтгэгчийн санхүүжилтээс авч ГСА-ын аргачлал, хяналтын зардлын дансанд төвлөрүүлнэ.
- 3.2.18. ГСА-ын аргачлал, хяналтын зардлаас энэ журмын 3.2.15, 3.2.16-д заасан зардлыг санхүүжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, төсвийг ҮГА-ны дарга батлаж, энэ журамд нийцүүлэн Сангийн яамнаас зөвшөөрөл авсны үндсэн дээр санхүүжилтийн эрхийг нээлгэн зарцуулна.
- 3.2.19. ҮГА нь ГСА-ын аргачлал, хяналтын зардлын санхүүжилтийн тайланг байгууллагын шилэн дансанд тогтмол байршуулж нийтэд мэдээлнэ.
- 3.2.20. Тухайн онд үргэлжлэх болон шинээр эхлэж байгаа ГСА хэрэгжих аймгийн Засаг даргын тамгын газар, холбогдох төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагад төслийн ач холбогдол, үр дүнгийн талаар мэдэгдэж, гүйцэтгэгч нарт холбогдох зөвшөөрөл авах, ажиллах нөхцөлөөр хангахад дэмжлэг үзүүлэх арга хэмжээг ҮГА хариуцана.
- 3.2.21. Шуурхай хяналт хийх болон хээрийн материалыг хүлээн авах хяналтын хуудсыг ҮГА-ны дарга батална.

## **Дөрөв. Геологийн судалгааны ажлын үр дүнг тооцох**

### **4.1. Геологийн судалгааны ажлын үр дүнг хүлээн авах**

- 4.1.1. Гүйцэтгэгч нь геологийн даалгаварт заасан хугацаанд үр дүнгийн тайланг зохиож, холбогдох чиглэлээр МСК, РЗ болон ЭБМЗ-өөс томилогдсон шинжээчийн дүгнэлтийг тус тус гаргуулан, яам болон ҮГА-ны холбогдох нэгжээр тойрох хуудасны дагуу хянуулж шаардлагатай засвар, өөрчлөлтийг хийсний үндсэн дээр ЭБМЗ-өөр хэлэлцүүлэхээр албажуулан хүргүүлнэ.

- 4.1.2. ГСА-ын үр дүнгийн тайланг ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлэхээр тойрох хуудас бөглөгдөж дууссан огноогоор геологийн даалгаврын хугацааг дууссанд тооцно.
- 4.1.3. ГСА-ын үр дүнгийн тайланг шинжээч хуанлын 30 хүртэл, холбогдох чиглэлээр МСК, РЗ хуанлын 30 хүртэл, яам болон ҮГА ажлын 5 хоногт багтаан танилцаж дүгнэлт, зөвлөмж, засвар, өөрчлөлт хийх саналыг гүйцэтгэгчид хүргүүлсэн байна. ГСА-ын үр дүнгийн тайлангийн хэмжээнээс хамаарч дүгнэлт, зөвлөмж, санал гаргах хугацааг ажлын 5 хүртэл хоногоор сунгаж болно.
- 4.1.4. Энэ журмын 4.1.3-т заасан хугацаанаас хоцорч дүгнэлт, зөвлөмж, санал хүргүүлсэн тохиолдолд гүйцэтгэгчийг ГСА-ын үр дүнгийн тайланг хугацаа хоцруулсанд тооцохгүй.
- 4.1.5. Гүйцэтгэгч нь 4.1.3-т заасан хугацаанд тайлангийн шинжээч, МСК, РЗ-ийн дүгнэлт, зөвлөмж, засварын өөрчлөлт хийх саналд хариу бэлтгэх ба зохих засварыг хийж эргэн танилцуулсан байна.
- 4.1.6. Гүйцэтгэгч нь ГСА-ын үр дүнгийн тайланг зохиогч, шинжээч, МСК, РЗ-ийн төлөөллийг байлцуулан ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлж хамгаална.
- 4.1.7. Төслийн үр дүнгийн тайланг ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцэж гаргасан тэмдэглэл, дүгнэлтийг үндэслэн сайд шийдвэр гаргана. Сайдын шийдвэрийг үндэслэн судалгааны ажлын үр дүнгийн тайлан, анхдагч материалыг энэ журмын 10 дугаар хавсралтын дагуу Геологийн баримтын төв архив (цаашид "ГБТА" гэх) хүлээн авч ҮГА-ны асуудал хариуцсан нэгжид тухай бүр мэдэгдэнэ.
- 4.1.8. ГБТА нь тайлан, анхдагч материалыг хүлээн авах тухай холбогдох эрх бүхий албан тушаалтны шийдвэрийг хүлээн авч, түүний дагуу гүйцэтгэгчээс энэ журмын 4.1.7-д заасан зүйлсийг хүлээн авснаас хойш ажлын 5 өдрийн дотор багтаан өөрийн архивын үйлчилгээний мөрдөх журам, зааврын дагуу бүртгэлд тусган дугаарлан баримтжуулснаар нийтийн хэрэгцээнд батлагдсан тарифт үнэлгээгээр үйлчилнэ.
- 4.1.9. Тайлан, холбогдох материалыг ГБТА-т хүлээлгэн өгсөн мэдэгдлийг үндэслэн ҮГА нь геологийн судалгааны ажил гүйцэтгэх гэрээг дүгнэсэн акт болон энэ журмын 11 дүгээр хавсралтын дагуу нэгтгэсэн төсвийн нэгтгэлийн хамт яаманд тухай бүр хүргүүлнэ.
- 4.1.10. ҮГА нь ГСА-ын арга аргачлал зөрчсөн, Захиалагчтай тохиролцолгүйгээр төсөлд заагаагүй ажил гүйцэтгэсэн, шуурхай хяналтын үед илэрсэн зөрчил дутагдлыг хугацаандаа арилгаагүй, актаар оногдуулсан төлбөр торгуулийг барагдуулаагүй, төсөл хэрэгжүүлэх явцад олж авсан геологи, эрдэс баялгийн ач холбогдолтой мэдээллийг нуун дарагдуулсан, төсөл дээр ажиллаж байгаа голлох мэргэжилтнийг 3-аас дээш удаа өөрчилсөн нь ажлын чанар, үр дүнд сөрөг нөлөө үзүүлсэн, ГСА-ын үр дүнгийн тайланг хугацаандаа ЭБМЗ-өөр хэлэлцүүлээгүй, ГБТА-д хүлээлгэн өгөөгүй гүйцэтгэгчийн санхүүжилтийг нь зогсоох, төлбөр, торгуулийг гүйцэтгэлийн баталгаанаас барагдуулах арга хэмжээг холбогдох хуульд нийцүүлэн шийдвэрлэнэ.
- 4.1.11. ҮГА нь энэ журмын 4.1.2-д заасан хугацаанд ГСА-ыг гүйцэтгэж дуусгалгүй улмаар хугацаа хэтрүүлэн үр дүнгийн тайланг ЭБМЗ-д хүргүүлсэн тохиолдолд хоцорсон хоног тутамд төсөлд зарцуулсан нийт төсөвт өртгийн 0.03%-тай тэнцүү хэмжээний алдангийг ногдуулан, ГСА гүйцэтгэсэн тухай гэрээг дүгнэсэн актад тодорхой заалт оруулан шийдвэрлэж, хэрэгжилтийг хангана.
- 4.1.12. ГСА-ын үр дүнгийн тайланг ЭБМЗ-өөр хэлэлцээд засвар, өөрчлөлт хийлгэхээр буцаасан хугацаанаас хэтрүүлсэн хоног тутамд энэ журмын 4.1.11-д заасан алдангийг мөн адил тооцно.

4.1.13. ГСА-ыг өөрийн санаачлагаар дур мэдэн зогсоосон, олгосон санхүүжилтийг зориулалт бусаар ашигласан, арга аргачлалын алдаа гаргасан, хангалтгүй гүйцэтгэсэн, ажлын үр дүнгийн тайланг зохиож ЭБМЗ-өөр хамгаалаагүй, тайланг үрэгдүүлсэн тохиолдолд уг төсөлд улсын төсвөөс зарцуулсан хөрөнгийг төсөл гүйцэтгэгчээр улсын төсөвт эргүүлэн төлүүлэх, 3 жилийн хугацаанд сонгон шалгаруулалтад оруулахгүй хар жагсаалтанд оруулах тухай саналыг ҮГА холбогдох эрх бүхий байгууллагад танилцуулж шийдвэрлүүлнэ.